

“ТАВАН ХОШУУ МАЛЫН МЭНД МЭДЭХ
СУДАР”-ЫН ТУХАЙД

До. Цэнджав*

“Улаан эрдэмтэн” Бархасын Банзрагч гуай гэх мөнөөх агуу их зохиолч Д.Нацагдоржтой хамт нэг дор ажиллаж байсан миний нутгийн өвгөнийг 30,40,50,60-аад оны боломжийн сэхээтнүүд андахгүй. Тэр хүн Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен авгай нартай дуун хөрвүүлэгийн хувьд ном хаялцахаар хэмжээний орчуулагч гэдгийг нэг бус хүний амнаас сонссон юм. Харамсалтай нь: Бо намын түүхээс авахуулаад В.И.Лениний ботиуд гээд дан марксизм, ленинизм улс төрийн номыг орчуулсан болохоор өнөөдөр яригдахгүй их л бүдгэрчээ. Эднийхэн тэр аяараа бичиг номын хүмүүс билээ.

Б.Банзрагч гуайн дүү их бага Цэнд гэдэг алдартай бичээч нар байлаа. Намайг нутагтаа далаад оны дундуур сургуулийн захирлаар хуваарилагдан очиход бага Цэнд бичээч дал гарчихсан хэрнээ ануухан байжээ. Гуулин том толгойтой, харваас бишрэм энэ лам бурхан шашны номын учир хийгээд дээр үеийн амьдралын талаар надад бишгүй олон зүйлийг ярьж өгч билээ. Тэр бүрийг тэмдэглэж аваагүй нь харамсалтай ч тархинд үлдсэн нь цөөнгүй. Манайхны удам угсааг гар дээрээ тавих шиг мэддэг ажээ. “Ээжийн чинь аав, та нарын бол өвөө аав болох ёстой Цэдэв тайж болбоос маш их номтой, цээж толгой сайтай, бичиг номын уран тансаг гоё хэллэгтэй, төвд монголоор жигд сайхан бичдэг цул эрдэм номын алт шиг хүн байсан. Одоогийнхоор бол эрдэмт хүн юм даа. Түшээт хан аймгийн Дайчин бэйсийн хошууны тамгыг баригч туслагч ноёны үе залгамжилсан хэргэм язгууртай ч түүнийгээ юман чинээ дээдэд боддоггүй эгэл хүн ардтай элс цас шиг холилдож явсан мэлтэрсэн уужуу сэтгэлтэй хүн байлаа. Бариа тавианы айхтар жилд хамгийн түрүүнд л татагдаж цаазлуулсан даа. Ийм хүн ардын дайсан байдаг нь яасан хачин юм бэ?” гэж гайхдагсан. Би хошуу тамгын газрын хэнээс ч дутахааргүй бичээч хүн. Бичээч гэдгээр хэлэгдэнэ. Манай Түшээт ханыханы бичгийн хэлбэр галбир өөр. Гэвч өвөөгийн чинь дэргэд биднүүс нохойн жогорхой л гэсэн үг. Ганц хошуу тамгын газар ч биш, дээр доргүй Цэдэв тайжтанг “Ерөнхий” гэж дуудна. Олбог ширдэг болцгоон алив хэргийг дээр доргүй гэлгүй ярилцана. Өвдөг дээрээ тавиад л дуртайтал бичнэ. Манай хонхортоо багтахааргүй эрдэм номтой хүн гэдгийг ганц би хэлэхгүй, мэддэг бүхэн хэлнэ. Дайчин бэйсийн хошууны тамгын газар мань Ерөнхийгийн гараар орохгүй бичиг айлтгал дээшээ явахгүй ээ. Түүнийг дээдсүүдийн гарт очсон байхад яалтгүй зарга мэдүүлгээ өөрийн талд авна даа. Үнэндээ манай ноёд түшмэд ихэмсэг дээгүүр толгойтой боловч бичиг эрдэмд дулихандуу шүү дээ. Бид хэчнээн мэрийж бичээд ерөнхийгөөр шүүлгэхэд “Алив хүүхээ хоёулаа дахиад

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

оролдоноо, ингэчихмээр юм биш үү? энэ үгийг үүгээр сольчихёё, тэгвэл сэвэлзээд явчих юм биш үү? ингэвэл утга нь ташаараад бүдгэрээд явчихаж магадгүй. Нэг үг түмэн учиртай. Түмэн учрыг мэдэхгүй ч гэлээ түнэр харанхуйг гэрэлтүүлэх нэгэн үгийг олж цохлохдоо л бичиг номун хүний чадал чансаа нь оршдог” гээд л цайруу шаралавтар талбиун нүүрэндээ цэлсхийтэл гэрэл гэгээ татуулан инээмсэглээд л засаж гарна. Бийрээр хурдан татах тусмаа гоё болдогсон.

Уур уцаар, хүнийг дорд үзэх дээрэлхүү, эрэлхүү зан ааш байхгүй. Улмаа л хөхиүн болоод инээмсэглэнэ. Хажуугаар өнгөрөхдөө толгой илнэ. Дандаа алиа марзан хачин юм ярина. Тун зовлонгүй хүн шиг харагдагсан. Тэгээд нэг хоёр өгүүлбэр завсраар нь оруулахад л нөгөө муу муутуу цаасан дээрх ноорхой бичиг амь ороод ирдэгсэн. Ёстой бичиг номын хүн. Өвгөн ахын чинь үзсэн юм, та нарын дэргэд юухан байхав. Гэхдээ би тийм хүнийг энэ насандаа үзээгүй. Хөөрхийг бодох бүр сэтгэл маналзаж өрөвддөг юм. Хүү чинь ингэхэд сургууль ном төгсөж монголтой болсон шиг байна. Танай их гэрт чинь тайжтаны өөрөө бичсэн, өөрөө зохиож найруулсан бишгүй л ном, сургаал байх учиртай. Би үзэж мэдэхийн хувьд хэлж байна. Үрэгдэх нь үрэгдсэн л байх. Их юмнаас тасархай нэг ч болохноо хуудас үлдээ болов уу? Түүнийг шагайх зав та нарт байхгүй биз дээ, тэгээд ч одоо цагийхан хуучны юмыг тоох биш дээ гэж билээ. Бусдын амнаас сонссон нь ганц энэ бишээ, Ишдорж гэгч наяд гарсан цагаан буурал сахалтай өвгөн танай өвөг эцэг тайжийг эртний тууж үлгэр гаргууд мэддэг, зарим зүйлийг өөрөө зохион сайхан ярьдаг байсан гэх.

Энэхүү өвгөн бичээчийн дурсан ярьсан хүн бол ижийн минь аав буюу бидний өвөө төрт улсынхаа үе угсаа, хэргэм зэрэг залгамжилсан Мэндбаяр хошуу туслагчийн хүү тэргүүн тайж Цэдэв бөлгөө. Хэн ч байлаа гэсэн ямар л төр байна сайн ч бай, муу ч бай түүндээ л зүтгэнэ шүү дээ. Манжийн төрт улсад, Богд хаант Монгол улсад, сүүлд Ардын засгийн үед засаглалын алба хашиж юу ч гэсэн төрийн бар тамганд зарлиг лүндэнтэй, түгээх зарлах бичигт данстай явсан хүн юм билээ. Ийм хүмүүсийг дээр үеийнхэн “Гурван төрд зүтгэсэн хүн” гэлцдэг. Монгол улс маань он удаан жил нөтгөртөлөө Манж Чин улс хэмээх харь гадныханд эзэмшдэгсэн ч гэлээ галав эртний Хүннү болоод их эзэн хаан Чингис хаанаас өвлөгдөн ирсэн тэнгэр төрөл язгуурт эрхэмсэг дээд төрт улс юмаа. Ах дүүс бид бүгдээрээ ийм удам угсаатайгаа намтар түүхээсээ тас нууна. Бүх намтартаа үгээгүй ядуу ардын хүүхэд л гэж бичнэ. Нэгэн айл гэрийн таван эрдэмт номт ахан дүүс удам угсаа гарал, тайж, гавж аграмба явсаныхаа төлөөснөө цаазлагдсан нь их ховор бөгөөд бараг байхгүй юм билээ. Ижий минь үүнийгээ илрэх вий гэж мөн ч их бүлтэлзлээ айх боловч нутгийн өвгөл эмгэд андахгүй ярина. Нэг бодлын миний бага залуу нас түүхэн явдалтай тийм ч холгүй байсан юм болов уу? Ямар ч байсан яс нь байхгүй ч нэр нь хусагдахгүй яригдана гэдэг гайхамшиг гэхээс яахав.

Цэдэв тайжийн тухай ухаан орох цагаас хойш чамгүйг сонсож, нэлээдийг чихнийхээ хажуугаар өнгөрөөжээ. Ижий минь, бага ээж хоёулаа “Аав минь тэгээд, ажгаа маань тэгэхэд хэдтэй байсан юмбэ дээ, хөөрхий аав минь тэгдэгсэн, аавын бичиг” гэж үе үе хөөрнө. Түүний гэргий Магсаржав хатантан “Чи санаанаасаа хачин хачин юм урсгадаг хүн. Алив чи нөгөөгөө эдэнд яриада, эртхэн унтуул” гэдэг байжээ. Зохиогч, үлгэрч, аман өгүүлэгч байсныг л оноож байгаа нэг баримт юм.

Манай гэрийн хоймрын арслантай эрээн авдрын зүүн талынхад гүнгэрваатай, гуутай бурхад, “Алтангэрэл” “Жадамба”, “Сандуйнжүд”, “Чойжид дагинын тууж”, “Молом тойны намтар” гээд нэр ус мэдэхгүй олон ном судар байна. Хөрөнгөө гурван

удаа хураалгасан гэхэд эд яагаад үлдсэнийг мэдэхгүй. Ном судрыг гаргана гэж үгүй. Андуу Рэнчин гэдэг хүн ирэхэд бүгдийг гаргаад уншуулж байсан нь санаанд үлджээ. Тэнгэр аягүйтвэл ээж минь “Алтангэрэл”- ээ аваад хэд тойроход үнэндээ их үер бороо, салхи шуурга намдах шиг болно. Бидний хэн нэгэн халуурч бүлээрч сандаргавал “Алтангэрэл” -ээр адислахад үгүй ядаж уйлалгүй унтаад өгөх жишээний. Энэ бол санаа дагасан хэрэг байж болох...

Энэ дотроос тайжтны өөрийн гараар бичсэн “Таван хошуу малын мэнд мэдэх судар” гэсэн бичиг гарсаныг угийн юм хадгалахдаа чамбай дунд ах Лувсанданзан цаг сайжраад ирэхэд, ерэн он гарангуут Гандантэгчилэн хийдийн Шашны дээд сургуулийн захирал, доктор гавж, Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн нэг ангийн сайн нөхөр Ш.Сонинбаяр ламтанд өгчээ. Угаасаа бичиг соёлын зүтгэлтэн тэрбээр ихэд олзуурхан утга зохиолын сод сонин бүтээл байна, олон түмэнд уншуулж тараамаар, эрдэмтэн мэргэд судалмаар, маш сонин сайхан язгуурын хэллэгтэй, яруу шүлэглэлт бүтээл байна. Танай өвөө Цэдэв тайжийн зохион туурвисан бүтээл байж болох бүрэн талтай. Би л лав янз бүрийн уншиж үзэж харж байхад ийм юм тааралдаагүй гэлээ. Тэр үеийнхэн хэнэггүй ч гэмээр юмуу, ганц хар биеийг магтан олонд гайхуулдаггүй толгой мэхэс, тойг сөхрөнгө байсан тул нэр усыг юман түрүү тавьдаггүй, тэгэж ч хэвшээгүй байжээ. Хэн нэгэн мэргэн цэцэн нь эхэлж гарган зохиож тэр нь ам дамжигдан яригдсанаар аман зохиол болдог нь ерөөс хууль. Энэхүү судрын эх баригч яахын аргагүй Цэдэв тайжтан юм байна гэдгийг утгын чимгийг нээх далд мэдрэмж, аман ярианы давхцал, цөөнгүй ижил тохиол, тааварлах магадлалын дэнс дээр шүүн тунгааж өөртөө итгэл үнэмшил болгож авсан юм.

Дайчин бэйсийн хошуу зүүн өмнөд талаараа Говь мэргэн вангийн хошуутай нутаг захдаж залгаа орших тул хуульч Сандагийн зохиолын хувилбар уу? гэж эргэлзтэл туурвих арга хэлбэр, аяс хэллэг нь огтхон ч таацахгүй магад өөр нь мэдрэгдэж байна. Цэцэн Сандаг бол “Ботгоноос салгаж жингийн хөлсөнд өгсөн ингэний хэлсэн нь”, “Ботго нь хойноос нь ингэж байгаа гэж хэлсэн нь”, “Шинэ тавьсан хурган хуцыг хэлсэн нь”, “Ороод хоцорсон буурыг хэлсэн нь” “Эцээд хэвтэж байгаа ухныг хэлсэн нь” гэх зэргээр дан хэлсэн үгээр нь бүтээдэг монгол эртний уран зохиолын нэгэн төрөл болох “Үг” зохиолын гол төлөөлөгч болно.

Хутаг ерөөлийн хүчээр

Хувьтай эзэндээ учраад

Хурган нэрийг олж

Хуялага хөгөндөө өчлөө гэх зэргийн мал адгуусыг хүнчилж амьтан малын өмнөөс төлөөлж хэлсэн маягаар бүх шүлгээ бичдэг байна. Амьгүй юмс, хэлгүй мал адгуусын өмнөөс хэлэхдээ тухайн үеийн амьдрал, хүмүүсийн санаа бодол, нийгмээ оруулан шүүмжилсэн өнгө аястай ч байх юм.

... Хийснээ чадаагүй хэвтэж

Хийгээр биеэ тоож

Хээр гаднагүй ихэрхэж

Үзээгүйг мэдсэн

Яваагүйг чадсан янзтай

Явдлыг сурсангүй

Ямбалахыг сурсан гэхчилэн чадмаг ядмаг албаны бичээчээр дамжуулан хиа, түшмэдийг шүүмжилсэн бүтээл бий. Ш.Сандагийн жирийн нэг мал амьтны ааш араншин, маяг хөдөлгөөн, төрхийг хараад л ер бийр гарган бичилгүй шуудхан цээжээр

хэлсэн болгоныг нийгмийн дарлагч, дарлагсад ангитай холбон “ангижуулж” тайлбарлах явдал ерөөс нэг бодлын төөрөгдөл байж болно. “Цэцэн” “мэргэн” хоёрын ялгаа юундаа байна гэхлээр цэцэн нь болохоор угийн цээжтэй саруул цэлмэг ухааны хүчээр шуудхан амаараа толгой холбоод шүлэглэн хэлчихдэг, мэргэн хүн нь ийм гарц дээр түгдрэн саатаж, цээжээр хэлж чадалгүй бийрээр бичиж үлдээгээрээ л ялгаатай болов уу? Цэцэн Сандаг гэж олондоо хүндэлдэг болохоор тэр яавч шуудхан хараад шүлэглэчихдэг байж таараа. Түүнийг нь ой сайтай хүмүүс дор нь тогтоож бичиж үлдэнээ. Өөрөө ч бас бичээ л биз. Адгуус малын зовлон түйтгэрийг өмнөөс нь өчсөн хурц ой ухаантай, авъяас билэгтэй цэцэн цэлмэг хүний айлтгасан сэтгэлийн өчил юм. “Үг” зохиолыг судалсан эрдэмтэн Х.Сүглэгмаагийн “Монголын уран зохиол дахь “Үг” зохиолын төрөл зүйл”, Өөлдийн Чимэдийн “Хуульч Сандагийн зохиолуудын түүвэр”-т “Халхын хуульч хэмээх цэцэн Сандаг” Г.Цэдэвдоржийн “Цэцэгт хонд” миний уран зохиолын багш багш Д. Готовын “Хуульч Сандагийн зарим зохиолын хувилбар” гэсэн бүтээлүүдэд ижил төстэй мөр бадаг, ижил сэтгэлгээтэй шүлэглэл байхгүй тул лав тэр зүгээс гаралтай биш байна.

Тэгээд ч энэхүү “Таван хошуу малын мэнд эрэх судар” бол “Үг” зохиол биш бөгөөд монгол хүн эрдэнийн таван хошуу эцэг малаасаа мэнд амрыг эрж байгаа морь малдаа хязгааргүй хайртай монгол малч ардынхаа хөхиүн хөгжилтэй сэтгэлийн яруу тайллыг харуулна. Малыг өхөөрдөнө, малыг хайрлана гэдэг язгуурын сайхан сэтгэл бусдад ховор, бараг байхгүй ч биз. Ингэж өдөр судар үзэн, сайн өдрийг сонглон өглөөний шинэ тунгалаг нарнаар эцэг малыг барин авч, яг хүн мэт дээдлэн хайрлаж, үгийг чихэнд нь шившиж, анд мэт нөхөрлөж, ойр мэт шадарлаж олны дундаас онцгойлон идээ цагаагаа дэлгэж, арц хүжээ уугиулж, хот хороогоо ариутгаж, хадаг мяндар уядаг, сэтэрлэдэг ийм сайхан зан заншил, ёс уламжлал, бэлгэдэл зүй ганцхан монголд л байна. Монгол монголдоо ганц манай нутагт байсан санжуу? Монгол хүн л, учрыг мэдэж ойлгоно уу гэхээс гадаадын хэн ч гайхна. Тэд лав гэр гартаа дасгасан нохой муураасаа мэнд амрыг эрэн асууж шүлэглэдэггүй биз. Байгаль, адгуус хүн амьтны хэлхээ холбоо нүүдэлчин амьдрал өөрөө. Монгол хүнийг нэн ялангуяа эртний монголыг таван хошуу малаас салгахын аргагүй. Малын мөр дагасан ухаан л монгол ухаан, монгол хэл, сэтгэлгээ, монгол ёс заншил, монгол жудаг ёс, монгол уужуу сэтгэл, монгол ууч хайрыг бий болгожээ.

Энэхүү судрыг найруулагч, нэвтрүүлэгч Жамъянгийн Батбаяр уран бүтээлчийн сэтгэлээр гойд олзуурхан, хүн хүнийхээ амар мэндийг ч олигтой эрж чадахаа больчихсон үед жинхэнэ холбиршгүй ариун сэтгэлээрээ таван хошуу эцэг мал бүрийнхээ амар мэндийг эрдэг ёс танай нутагт л байдаг юм байна. Өвгөн чинь бүтээл хийнэ гэж намайг шавдуулж 2008 оны намар өвлийн заагаар Дундговь аймгийн Гурвансайхан нутагт минь цуг очиж телевизийн даацтай бүтээл хийж үлдээсэн. Хэдийгээр тарчигдуу цаг байсан ч гэлээ сумын удирдлагууд хаа байсан газраас таван хошуу мал, тэр дундаа эцэг малыг оролцуулан суурь сууриар нь тууварлан авчирч манайхны олон арван жилийн турш нутаглаж ирсэн Баруун Сэвхүүлийн талд хуран цуглуулан том хэмжээний зураг авсан юм. Угтах жилийнхээ цагаан сараар нийтэд үзүүлсэн билээ. Энэ мэтээр “Таван хошуу малын мэнд эрэх судар” хүмүүсийн анхаарлыг татаж хууч домог, уламжлалт ёс заншил, удам угсаа, ардын билгэ зүй, бөө мөргөлийн соёл, хүн судлалын маш өргөн талт жинтэй судалгаа хийдэг, тэрхүү бүтээлээрээ монголдоо төдийгүй дэлхийн соёлт улс орнуудын эрдэмтдийн анхаарал таашаалын дунд явдаг эрдэмтэн Сэндэнжавын Дулам үүнийг надаас ихээхэн олзуурхан

сонирхсон юм. Аль нааяд оноос Монгол орныхоо дийлэнхээр явж нутаг нутгийн хөгшдүүдтэй амьд сэрүүнд нь уулзаж, амаас нь алив ховор зэвэр бүхнийг тэмдэглэн амьд судалгаа хийсэн энэ эрдэмт хүмүүн ийм таван хошуу малын амрыг эрсэн бүтээлтэй огт учраагүй гээд бидний Бага ижий гэж хүндлэн авгайлдаг Дайчин бэйсийн хошууны тамгыг захирагч түшмэлийн охин Бүжээтэй уулзаж удаан хуучилсан нь ер бишийн зүйл гэж бодно. Тэрбээр ноён удамт сүүлчийн охин олны юмны гэрч болсоор ухаан санаа эрүүл саруул, үг яриа эндүү андуугүй байсаар бараг зуу насалж, 2010 оны долдугаар сарын эхээр тэнгэрт хальсан билээ. Язгууртны сүүлчийн охин байсан бизээ. Овсгоотойсон бол түүхийг амьдаар нь үлдээх ёстойсон. Нэгэн баримтат киноны гол баатар ингэж чимээгүйхэн байсаар, хэрэндээ бичгийн гэхээр бидний дэргэдээс алга болжээ.

Олны амнаас сонсвол Цэдэв хэмээгч нь энэ байтугайг хийчих авъяас, билэг оюунтай бичиг номын хүн байж дээ. Бичиг номыг чадлын хэрээр дээдэлдэг бидний өвөг эцэг буюу Түшээт хан аймгийн Дайчин бэйсийн хошууны “Ерөнхий” хэмээх тэргүүн тайж Мэндбаярын Цэдэвийн энэхүү бичиглэн үлдээсэн “Таван хошуу малын мэнд мэдэх судар”-ыг бүрэн эхээр нь хоёр дахиа олон түмнээ толилуулж байна. Эрдэмтэн мэргэд нэгийг хэлж, үүнийг нэгэн тийш болгоно бизээ. Өөр газарт нутагт өөр хувилбар ч байж болох юм. Огт өөр хүний зохиол туурвил байнаа гээд баталж нотолбол бид урвайж дургүйцэх зүйл огтхон ч үгүй. Яагаад гэвэл үүнийг танай өвөг эцэг л зохиосон байх учиртай гэсэн аман яриа л байгаа болохоос гэрчлэх юм алга. Бүүр эрт дээр үеэс уламжилж ирсэн аман зохиолыг өвөө маань бичгээр тэмдэглэж үлдээсэн ч юмуу төсөөлөх юм алга. Ямар ч байсан энэ судар бидний гарт байдаг юмаа. Үүнийг мухарлах гэж ч тэмцсэнгүй. Харин зохист аялгууны тансаг хэллэг, зүйрлэл адилтгал, чимэглэлт үг, ёжлол ёгтлол, утга санаа, хэл найруулга, бүтээлийн туурвилын онцлог, бүтэц хэв маягийн хувьд маргах юмгүй онцгой сонин сайхан шүлэглэлт судар бичиг болно.

“ТАВАН ХОШУУ МАЛЫН МЭНД МЭДЭХ СУДАР”

Хулан цуглартал янцгаадаг
Хүлэг цуглартал унгалддаг
Адуу бүхний эцэг болсон
Азарга жанжин эрх үйзэн
Эрдэнийн хүлэг идэр мэнд ?
Жороо сайвар хийгээд
Тархай хатир явдалтай
Элдэв зүйлийн өнгө бүрдэгсэн
Очир дара Богд гэгээний
Хөлөг бүхэн мэнд үү?
Улаан ядамын сэтэрт халиун морь
Гомбын сэтэрт хар морь
Лхам сахиусын сэтэрт хонгор халзан морь
Улаан сахиусын сэтэрт хурдан зээрд
Далхын сэтэрт цагаан морь
Атааны сэтэрт хөх бор морь
Арилжиж хатирдаг цавьдар морь

Уургын алаг урт шарга морь
 Хонины бор, хотгор зээрд
 Хаздаг хар, хайрдаг буурал
 Хамаг олон агт сүрэг бүхэн мэнд үү?
 Хур дэл нь газар хүрсэн
 Хууч тарга нь хондлойдоо хүрсэн
 Айраг найр үүсгэн гаргадаг
 Адуу бүхний эх болсон
 Аль олон гүү хийгээд
 Үрээ, байдас; унага даага
 Үй түмэн адуун сүрэг мэнд үү?
 Зуугаас нааш газрыг
 Зуу мянгаар товчлон ирдэг
 Бээжингээс нааш газрыг
 Бэрх хатуужлаар яваад ирдэг
 Очих гэсэн газартаа очдог зоригтой
 Хүрэх гэсэн газартаа хүрдэг чадалтай
 Хүмүүний чинээ бөхтэй
 Хүрзэн чинээ тавагтай
 Арьс шир, алт мөнгө алиныг ч
 Ачуулаад зүдэрдэггүй
 Урт гэгч хүзүүтэй
 Амьтнаас ангид дуутай
 Арван хоёр жилийг багтаан төрсөн
 Буур ат болд нягт хурц билэгт
 Ингэ, тором, тайлаг хийгээд
 Ер тэмээний аймаг бүхий мэнд үү?
 Уулын цаана дуулдтал урамддаг
 Улсын үхрийг цуглартал мөөрдөг
 Үнээ нэгийг ч хусраадаг үгүй
 Үхэр нэгийг ч мөргөдөг үгүй
 Бүдүүн хүзүүт их хүрэн бух
 Жонон эрх үйзэн идэр зайсан мэнд үү?
 Тэргэнд явахдаа тэсгэл үгүй сайн
 Түлээ ачихад тунчиг сайн
 Нуруу ачихад нугас шиг түргэн
 Анжис тариа тарихад аюул үгүй сайн
 Аль олон амбан шарууд бүхий
 Идэр заан шинж бүрдэгсэд мэнд үү?
 Зайлал үгүй саалгадаг
 Гэлэл үгүй бэлчдэг
 Хураал үгүй ирдэг
 Хусрал үгүй тугалладаг
 Хувин дүүрэн гардаг
 Хөмрүү, солжир, мухар халзан
 Хүрэн тарлан тэргүүнтэн

Хөгшин залуу үнээ бүхий нягтууд мэнд үү?

Ууланд очиж хөдөөлдөг улаан бух

Улсын үхэрт тэнэн явдаг тарлан бух

Шөрөгтэй бяруу, шүдлэн гунж хүртэл

Өвгөн мялзангийн дайснаас гэтлэгсэн

Үхрийн аймаг бүхий мэнд үү?

Дугариг эвэртэй, дун бүрээ шинжтэй

Цагариг эвэртэй, цагаан үстэй

Төгрөг эвэртэй, төө үстэй

Хонины хаан хуц мэргэн дайчин мэнд үү?

Шар халзан, хар халзан

Хар түрүүт, улаан хүзүүт

Бор халзан, хундан цагаан

Тавгийн чинээ сүүлтэй

Тарган тарган цагаан

Ирэг бүхий идрүүд мэнд үү?

Жил жилийн төл огт алддаггүй

Эрх үйзэн эмгэн хониуд хийгээд

Зусаг төлөг хэнз хавчрай

Ер хонины сүрэг бүхий мэнд үү?

Газар чирэм сэвэг зогдортой

Галзуурсан их дочигтой

Ганц сав хогшилтой

Сэлэм шиг эвэртэй

Сэрэмхий мэргэн ямааны ноён

Ухна жонон эрх үйзэн идэр ланс мэнд үү?

Галын сэтэрт хөх сэрх

Алж иддэг үгүй алаг сэрх

Арилжаанд зардаг үгүй орог сэрх

Алба ахуй аль юманд зардаг

Амь олон сэрхэн ямаад бүхий мэнд үү?

Өнтэй жил гурав дахин хэнзэлж

Хачрайлан, дахлайлан ишиглэдэг

Өн үгүй жил магад хоёр алдах үгүй ишиглэдэг

Үнээ мэт дэлэнтэй

Бүрээ мэт уянгалсан дуутай

Эрх үйзэн эмгэн ямаа суутангууд хийгээд

Тэргүүлж явдаг түгжир хув ишиг

Онцгойлж явдаг орог саарал ишиг

Захад явдаг загал буурал ишиг

Хамуу годронгийн аюул бүгдээс гэтлэгсэн

Хамаг олон ямаанууд мэнд үү?

Эндээс харин “Хулан цуглартал янцгаадаг” гэдэг үг харин энд тэнд тааралддаг шиг санагдаж байна. Бүрэн эхээрээ ийм л үг хэллэгтэй судар л даа. Номын их гэгээнтэн Цэндийн Дамдинсүрэн гуайн 1959 онд монгол бичгээр оршил бичиж эмхлүүлсэн “Монголын уран зохиолын дээж зуун билэг оршвайд” ч өртөж орсонгүй. Хэрвээ тэр их

эрдэмтний гарт баригдаж олдсон бол лав л авч шидэхгүй байх. Энэхүү “*Зуун билиг*” хэмээх гайхамшигт судар шастирын 581-р талд “*Туулай, төлөг, чоно гурвын үлгэр*” - Дорж мэйрэнгийн нэр дээр гаргасан байдаг. Тайлбартаа “*Халхын Дорж мэйрэн ардын аман зохиолыг ашиглан боловсруулж хорьдугаар зууны эхний үед энэ зохиолыг бичжээ*” гэсэн байна. Бидний өвөө ч хожим сангийн яамны сайд болтолоо явж бас л элдэв муу үг хавчилганд өртөн хэлмэгдэн шоронд орж 1940 онд нас барсан бичиг номын их хүн Дорж мэйринтэй тэр үеийн Өмнөговь хэмээх нэгэн аймгийн яг нэгэн цаг үеийн хүмүүс юм. “*Монгол хэлний тайлбар толь*” хийхээр олон жил зүдэрч махарч байсан ч түүнийгээ үзэж чадаагүй гэдэг. Үлгэрийг засамжлан Монголын эртний шилдэг зуун зохиолын тоонд тэр хүний нэрээр орж байхад энэхүү “*Таван хошуу малын мэнд эрэх судар*” Цэдэв тайжийн нэрээр нэрлэгдэн бичиг ном, товхимол, гарын авлага, эрдэм шинжилгээний бүтээл зохиолд үлдэх хувь зохиол байж болох юм. Үүнтэй адил төстэй зохиол Ринчен авгайн судалгаанд ч тэмдэглэгдээгүйг шүүрдэж үзлээ.

Энэхүү судар бичиг ойр хавьдаа нэг их тархалгүй, тархаж ч амжилгүй яг миний гал голомт гэрийн номын авдаранд түгжигдэн хав дараатай байсаар бидний гарт ирсэн нь тодорхой болов. Хэрвээ тархсан бол ядаж ганц нэг хүний аманд хэд гурван мөр нь ч болохноо өгүүлэгдэх учиртай. Сортоотой нэгэнд шүүрдэгдэн баригдах ёстой.

Монголын ахуй амьдрал дундаас яргаж гарч ирсэн, цэцэн билэг ухааныг усны ундарга мэт харуулсан сонгодог бичгийн ч гэж болох энэ судрыг тайлан утгыг ухахдаа энэ талаар шохоорхдог, судалгаа хийдэг эрдэмт хүмүүнд тус нэмэр болуужин хэмээх үүднээс гаргаж тавьсныг ойлгох бизээ. Мэргэд юунд ашиглаж, юунд үлдээх, юунд дурьдах, юуг авч гээх, юунд маргах таамаг дэвшүүлэх нь өөрсдийн хэрэг болой. Хэдийгээр удам угсаа, үндэс гарваль нэг болох хөвүүд бид оюуны өмчийг тэр хүний өмнөөс авах зориг зүрхгүй, аваад ч хэрэггүй бараг ардын аман зохиолоос ялгагдахааргүй шахуу болчихсон энэхүү судрыг ашиглахдаа харин бичгийн мэргэн, бидний өвөө Мэндбаярын Цэдэв хэмээх хүний нэрийг аль нэгтээ дурьдаж байвал аль эрт хэлмэгдэн цаг бусаар үгүй болсон тэр хүний алдар нэр жаахан ч ариусвал бид эрхтгүй баясана. Үндэсгүй, салаа мөчиргүй мод байдаггүйн адил өдий зэрэгтэй бичиг номын тоосонд унгиралдаж яваа мань мэтэс үүнийг номун цагаан хуудсанд бичиглэн үлдээх нь чухамхуу хувь зохиол гэж үзлээ.

“*Таван хошуу малын мэнд мэдэх судар*” бол хэн нэгний амнаас амархан унах жирийн суман цагаан задгай шүлэглэл бус, толгой холбосон хов хоосон цэцэрхэл бүр ч биш, болхи толхи эгэл бор бааз илбэдсэн цагаан магтаал ч биш, бурханлаг шүншигт гэгээн мөртлөө ерийн иргэний өнгө аястай, цаашилбал төрийн бэлгэдлийг ч шингээсэн, нүүдэлчний тархмал өргөн амьдрал ахуйтай, цаанаа холоос гэрэлтсэн гүн гүнзгий утга санаатай, эх хэлний эрдэнийн бадмаараг очис үе үе хаялсан, бидний ч мэдэхгүй, тайлбар толь бичгэнд ч тааралдахгүй үг хэллэгтэй ардын тэжээх ухаан тэнгэрийн цахилгаан цэнэг мэт хуран хуралдсан, монгол ахуй сэтгэлгээний жинхэнэ шим тэжээл бүхий рашааны дусал мэт дорвилог бүтээл гэдэгт хэн бугай ч лавтайяа эргэлзэхгүй.

“*Очир дара Богд гэгээний, Улаан ядамын сэтэрт, Гомбын сэтэрт, Лхам сахиусны сэтэрт, Далхын сэтэрт*” гэхчилэн таван хошуу эцэг малыг бурханы хамаат, буян хишгийн даллагат сүрэг гэдгийг яруу тод онцолжээ. Үүний зэрэгцээ төрийн бэлгэдэлийг хамаатуулахаа орхисонгүй. Төрийн дээд хэргэм зэрэг болох хаан, жанжин, зайсан, жонон зэрэг дэс цолыг мал дээр аваачиж дүрсэлсэн нь эцэг малын дүр төрх, араншин, сүрийг илүү хүчтэй товойлгож шашин, төрийн арга билгэдлийг эрдэнийн

очир мэт зангидаж чадсан нь баршгүй баригдашгүй мэдлэгийн ай савтай л хүний хийх ажил гэдэг нь мэдрэгдэнэ.

Мал бүрийн дүрийг *“Хонины бор, хотгор зээрд, хаздаг хар, хайрдаг буурал, хөмрүү солжир, мухар халзан хүрэн тарлан”* гээд марзан Шаравын нэгэн өдрийн зураг мэт ой тойнд тов томруун харагдахаар дүрсэлжээ. Тэмээний хувьд *“Бээжингээс нааш газрыг бэрх хатуужлаар яваад ирдэг, хүмүүний чинээ бөхтэй, хүрзэн чинээ тавагтай”* гэж бэлэн цэцэн атлаа түүхэн үнэнийг нээж харуулсан байх юм. Одоо цагийнхан Бээжин хүртэл галт тэргээр явахаас ч бэрхшээдэг болчихоод байхад манай жинчид аянчид хаа хол хангайгаас ч хамаагүй тэмээн жингээр идэж уухаас идээ будаанаас авахуулаад, бөс бараа даавуу торго, агаруу гүц сав эдлэл хэрэглэлээ татаж авчирч байсан нь одоо нэгэнт итгэхийн аргагүй домог болжээ. Энэхүү ховор түүхийг ч энд сануулж үлдээсэн нь үнэ цэнтэй байна.

Одоо ноолуур, сүү, хялгас арьс, мах өөх гээд хамаг л ашгаа хониноос илүү өгдөг ямаагаа адалж хэрхэн цөөрүүлэх тухай яриа хаа сайгүй байх юм. *“Үнээ мэт дэлэнтэй, бүрээ мэт уянга дуутай, сэлэм шиг эвэртэй, сэрэмгий мэргэн ямааны ноён”* гэж алдаршуулан бусдаас ер дутахааргүй магтжээ. Ямаа ямар хулан тахь биш дээ, хөөрхий түүнд хатуу газрыг сэндийлээд, үндсээр нь огло огло ухаад байх туурай, эвэр хошуу байх биш, харин ч нэг газар удаан тогтуурдаггүй, цэцэг ногооны толгой түрүүг хошуу хүргэхийн зуур сэрэмчиж шүргээд шүргээд л өнгөрдөг хүнд хамгийн ойр дотнын амьтан. Хүйтэн хошуутай л гэгцгээдэг, мөхөс би таван хошуу малын дотор хүйтэн хошуут мал нэг ч үгүй гэж дотроо мунхагладагаа энэ ташрамд гаргачихъя. Хүйтэн олтгой явдал, хүйтэн тохиол, хүйтэн гай цээр, хүйтэн тахал өвчин, хүйтэн ааш аяг гэдгийг таван хошуу малаасаа даанчиг мэдрэлгүй ариун цагаан сүүгээр нь угжуулж өссөн учраас бүгдийг халуун хошуут мал гэж магтъя даа.

Жинхэнэ язгуур монголын хольцгүй угшил бүхий хэл найруулгын маяг, донж таарсан төгс дүр дүрслэхүй, дээр дороос тулгаж шахсан хэв янз үзлийг бариагүй жинхэнэ монгол шүлэгчийн өөрийн чөлөөт бодрол, бясалгалын учиг дундаас амилсан нэгэн бодлын амьд найраглал гэж болохоор. Эртний шүлэглэлт зохиолд тэр бүр тааралдаад байдаггүй *“Зохист аялгуу”*-ны журам горим болохуйц чимэг үг хэллэг бишгүй байх юм. *“Азарга жанжин эрх үйзэн”, “Жонон эрх үйзэн идэр зайсан”, “Эрх үйзэн эмгэн хонинууд”, “Сэрэмгий мэргэн ямааны ноён”, “Ухна жонон эрх үйзэн идэр ланз”, “Эрх үйзэн эмгэн ямаа суутнууд”* гэж тэр цагийн эрхэм дээдсийн ямба хэргэмийн цол гуншинтай аваачиж дүйцүүлэн өргөмжилсөн нь сонирхлыг эрхбиш татна. Энд халуун сэтгэлээс ундрал гарсан егөөдөл оршино. Өөрөө ч алиа марзан юм ярьдаг, дэргэдэхээ инээлгэдэг нь зан чанар эндээс илэрч байна. Цаашилбал таван хошуу малын эцэг нэг бүрийг алдаршуулан эрхэмлэж нэг нэг таарсан цол гуншин олоод өгчих жишээний. Мал бүрийн онцлогт таацуулан энэ эрхэм тансаг учрын амар олмооргүй хачирхалтай ч гэмээр хэн ч бодоод амархан хэлчихээргүй үгийг таацуулан наалдуулж өгчээ. Үүний цаана л жинхэнэ ховор авъяас билэг нуугдаж байна. Ер бусын үг орж ирнэ гэдэг ер бусын хүмүүний чанарыг илтгэнэ.

Малдаа хайртай, түүнээ эрхэмлэн дээдэлдэг сэтгэлийг үүнээс илүү гаргах хэцүү. Өнөө цагийнхан ойлгох нь бүү хэл монгол хэлний их тайлбар тольд ч ороогүй язгуурын монгол үг хэллэг бишгүй гялалзана. Шүлэглэлийн байдлыг үзвээс ер жирийн буурай бичээч бус уран сэтгэмж, урлахуйн эрдэм, ухааны мэлмий нээхүйд тайлагдсан эрдэмт хүмүүн гэдгийг нотлоход ухаан зараад байхын хэрэггүй ажээ. Шүлгийн мөр, шад дотор ганц ч гэсэн егөөдөл, хошигнол, содон хэлц байх нь адтай сонирхолтой байдаг

төдийгүй үүнийг зохиогч үнэмшилтэй хийж өгвөл амьд болдог. Ийм тохиол хэд хэдэн газарт үзэгдэнэ. “*Үнээ нэгийг ч хусраадаггүй, галбирагсан жан сахалтай, галзуурсан их дочигтой, хамуу годронгийн аюул бүгдээс гэтэлсэн*” зэрэг үгүүд юм.

Янз бүрийн завсрын онол шүүн тунгаанд баригдаагүй, шүлэг найраг яаж бүтэхийг ч мэдэхгүй, зөвхөн төрмөл авъяасаар зөнгөөрөө бичиж үлдээсэн энэхүү бүтээл нь сонгодог шүлэг бүтээлийн сор болдоггүй юмаа гэхэд сонжиж шоовдорлох бүтээл бишээ. Монгол хүн монгол газар шороо байсан цагт монгол мал байж л байна. Монгол хүн малаасаа салаад хаачихав, монгол л биш болно. Монгол мал ахуй байж ахуй цагт энх төрийн сүргээс хүртэл амар мэндийг асууж өвчин эмгэггүй, чийрэг цовоо сэргэг, шандас чанга, туурай хурц бөгөөд сүрэг бүхний манлай явахыг хольцгүй чин сэтгэлээсээ ерөөсөн, дээдэлсэн, бахадсан, монгол хүмүүний дуулал энэ болой хэмээн хэлэхээс аргагүй хүрэв.